

БАТЛАВ:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Т.ЖАМБАЛЦЭРЭН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛСЫН ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР  
МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮС НУТАГТ “СҮҮНИЙ ЧИГЛЭЛИЙН  
600 ҮНЭЭ БҮХИЙ ЭРЧИМЖСЭН ЦОГЦОЛБОР АЖ АХУЙ БАЙГУУЛАХ” ТӨСӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧИГ

“Сүүний чиглэлийн 600 үнээ бүхий эрчимжсэн цогцолбор аж ахуй  
байгуулах” төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн  
чадавхийн мэдээлэл

Баримт бичгийн дугаар: ТШ/20/03/13

Улаанбаатар хот 2020 он

<b>1.Төслийн зорилго</b>	<p>1.1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг эрчимжүүлэх.</p> <p>1.2. Төсөл нь Бүгд Найрамдах Беларусь Улсын экспортын зээлийн хөрөнгөөр Монгол Улсын газар тариалангийн бүс нутагт сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийн эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулан таримлын сэлгээг нэвтрүүлэх замаар олон улсын стандартын шаардлагад нийцсэн үржлийн өсвөр үхэр бойжуулах, сүү үйлдвэрлэн дотоодын зах зээлийг эрүүл аюулгүй сүүгээр ханган, энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын жижиг дунд аж ахуй эрхлэгчдийг үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчийн сайн чанарын үрээр хангах, үйл ажиллагаа явуулах дадлага туршлага бүхий аж ахуйн нэгжүүд сүүний чиглэлийн цогцолбор аж ахуйг бий болгоход чиглэгдэнэ.</p>
<b>2.Төслийн шат</b>	<p>2.1. Сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжүүд бүрдүүлсэн баримт бичгээ битүүмжлэн хүлээн авах хугацаанд биеээр эсвэл цахимаар ирүүлнэ.</p> <p>2.2. Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн баримт бичгүүдийг Ажлын хэсэг хянаж, эхний шатны шалгаруулалтыг явуулна.</p> <p>2.3. Шалгарсан аж ахуйн нэгжийн цогцолбор барих газар дээр Бүгд Найрамдах Беларусь Улсын шинжээчид ирж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сүүний чиглэлийн 600 үнээ бүхий эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулах ажлыг эхлүүлэх, Төсөл хоёр үе шаттай явагдана.Үүнд: - <b>Эхний үе шатанд:</b> Гэрээний нөхцөлд заасны дагуу Төсөл хэрэгжүүлэгчтэй сүүний чиглэлийн 600 үнээ бүхий фермийн иж бүрэн цогцолбор байгуулах ажлын гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд зохион байгуулна. - <b>Хоёр дах үе шатанд:</b> Ажлын хэсэг нь стандартын шаардлага хангасан 600 үнээ бүхий фермийн иж бүрэн цогцолборыг хүлээн авч акт үйлдсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээг байгуулан, цогцолборыг ашиглалтад хүлээлгэн өгнө. Уг цогцолбор нь гэрээний хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны өмчлөлд байх ба төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж нь зээлийн төлбөрийг 7 жилийн хугацаанд хуваарийн дагуу жил бүр мөнгөн хэлбэрээр төлнө.</p> <p>2.4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь төсөл хэрэгжих явцад цогцолборын үйл ажиллагаа, ашиглалт, зээлийн эргэн төлөлтөд байнгын хяналт тавина.</p> <p>2.5. Зээлийг бүрэн төлж, тооцоо нийлж гэрээг дүгнэсний дараа уг цогцолбор тухайн аж ахуйн нэгжийн өмчлөлд бүрэн шилжсэнээр гэрээ дуусгавар болгоно.</p>
<b>3.Импортын үхэрт тавигдах шаардлага</b>	<p>3.1. Импортоор авах үхэр нь 14 сараас доошгүй настай, сүүний чиглэлийн Хар тарлан, Симменталь үүлдрийн стандартын шаардлага хангасан хээлтэгч, 1-3 сар хүртэлх хээлтэй байна. /Импортоор авах сүүний чиглэлийн өсвөр үхрийн 3 хувиас илүүгүй хээлтүүлэгч байж болно/.</p>

**4.Төсөл  
хэрэгжүүлэгчи  
д тавигдах  
шаардлага**

- 3.2. Үхрийн удам гарвал нь тодорхой, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг хугацаанд нь хийсэн, эрүүл болохыг нотолсон эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй үхэр байна.
- 3.3. Импортоор орж ирж байгаа үхрийн амьдын жин нь 230 кг-аас доошгүй, галбирын хувьд ямар нэгэн согоггүй, эрүүл бойжилттой байна.
- 4.1. Сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгж нь Монгол Улсын Засгийн газрын 131 дугаар тогтоолоор баталсан Газар тариалангийн бүс нутагт багтсан байх.
- 4.2. Тухайн аж ахуйн нэгж нь мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ явуулах бүрэн чадавхитай мэргэжлийн боловсон хүчинтэй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэдэг байх.
- 4.3. Жилийн турш байнгын болон нэмэгдэл тэжээлээр хангах хэмжээний өвс, хүчит тэжээлийг тариалж бэлтгэх хөрөнгө, техник хэрэгсэл, ажиллах хүч, санхүүгийн чадвартай байх.
- 4.4. Үр тариа, тэжээл, буурцагт таримал бүрэн боловсрох боломжтой бүс нутагт 1500 га-гаас багагүй эргэлтийн талбайтай, жилд дунджаар 800-аас доошгүй га-д тариалалт хийдэг байх,
- 4.5. Аж ахуйн хэрэгцээнд малын тэжээл үйлдвэрлэх, дарш бэлтгэх чадахитай байх
- 4.6. Төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэртэй холбогдсон байх.
- 4.7. Үр тариа, тэжээлийн болон буурцагт таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлэх талбайн болон техник, тоног төхөөрөмжийн боломжтой байх.
- 4.8. Тариалалтыг 7-10 хоногт, уриншийн нэг удаагийн боловсруулалтыг 14 хоногт, ургац хураалтыг 14-21 хоногт багтаан гүйцэтгэх техникийн чадамжтай байх.
- 4.9. Усалгаатай тариалан эрхэлдэг, эсвэл усалгааны эх үүсвэрт ойр 200-гаас доошгүй га талбайд усалгаатай тариалан эрхлэх боломжтой байх,
- 4.10. Сүүлийн 5-аас доошгүй жил үр тариа, тэжээлийн таримал ургамал тариалсан туршлагатай, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа мэргэжилтэн болон мэргэжлийн агрономич, механикжуулагчидтай байх,
- 4.11. Эрх бүхий байгууллагаар барьцаа хөрөнгийн үнэлгээ хийлгэн баталгаажуулсан байх;
- 4.12. Төсөлд оролцогч нь аливаа банк, санхүүгийн байгууллагад чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх;
- 4.13. Хөдөө аж ахуйг дэмжих санд хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;

**5. Төслийн  
санхүүжилт**

- 5.1. Төсөл хэрэгжүүлэх чадвар, төслийн цар хүрээ, ажлын онцлогтой уялдуулан 5-с доошгүй ААН-ийг сонгон шалгаруулна.
- 5.2. Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлээр санхүүжих нэг цогцолбор ферм байгуулахад гарах зардлыг шалгарсан аж ахуйн нэгжийн байршил, орон нутгийн онцлогтой уялдуулан гаргасан зураг, төсөл ТЭЗҮ-ийг үндэслэн тогтооно.
- 5.3. Зээл авагч нь 7-н жилийн хугацаатай, жилийн тодорхой хувийн хүүтэй зээл авах бөгөөд эхний 2 жил үндсэн зээлээс чөлөөлөгдөх нөхцөлтэй ба төсөл хэрэгжилтийн явцад Зээлдүүлэгчийн зүгээс тогтмол хяналт тавих ба мэргэжил арга зүйгээр хангана.

- 5.4. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь иж бүрэн цогцолбор фермийн үнийн дүнгийн 15 хувийг урьдчилж төлөх нөхцөлтэй ба тухай ААН өөрөө төлж чадахгүй тохиолдолд төлбөр хийх санхүүгийн байгууллагыг оролцуулж болно.

**6. Төсөлд оролцогчийн бүрдүүлэх бичиг баримт**

Төсөлд оролцогч дараах баримт бичгийг ирүүлнэ:

- a) Төсөлд оролцохыг хүссэн албан бичиг
- b) Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын тодорхойлолт.
- c) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/
- d) Сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;
- e) Тариалангийн эргэлтийн талбайн хэмжээ, газар эзэмших эрхийн гэрчилгээ болон тариалангийн талбайн байршил, үр тариа, тэжээлийн таримал тарих, хураах, тэжээл бэлтгэхэд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт.
- f) Газар тариалангийн бүс нутагт сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийн иж бүрэн цогцолбор ферм байгуулах газрын байршлын зураг.
- g) Усалгаатай болон услах боломжтой талбайн байршлын зураг.
- h) Төслийг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл, мэргэжлийн үнэмлэх, димломын хуулбар;
- i) Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүйг нотолсон харилцагч банкуудын тодорхойлолт;
- j) Хөдөө аж ахуйг дэмжих сантай тооцоо нийлсэн акт, тус санд хугацаа хэтэрсэн өр төлбөргүйг нотолсон тодорхойлолт.
- k) Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа, татварын өргүйг нотолсон харъяалах татварын албаны тодорхойлолт;
- l) Санхүүгийн чадавхийг харуулсан 2018, 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
- m) Шүүх байгууллагын тодорхойлолт.

**7.Төслийн баримт бичгийг тодруулах**

Төсөлд оролцогч нь төслийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.

**8.Төсөл шалгаруулалт ад оролцох зардал**

Төсөлд оролцогч төслөө бэлтгэх, ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд эдгээр зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
ЧАДАВХИЙН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ УРИЛГА**

Огноо: 2020.03.13

Сонгон шалгаруулалтын нэр: **“Сүүний чиглэлийн 600 үнээ бүхий эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулах” төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах**

Баримт бичгийн дугаар: ТШ/20/03/13

“Бүгд Найрамдах Беларусь Улсын экспортын зээлийн хөрөнгөөр Монгол Улсын газар тариалангийн бүс нутагт Сүүний чиглэлийн 600 үнээ бүхий эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулах” төсөл хэрэгжүүлэх сонирхолтой аж ахуйн нэгжүүдийг чадавхийн мэдээлэл ирүүлэхийг урьж байна.

Чадавхийн мэдээллийг битүүмжилж 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 15:00 цагаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтэст ирүүлнэ үү.

Мөн цаг үеийн нөхцөл байдал, шинэ Коронавирус (Covid-19) -ын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор чадавхийн мэдээллийг PDF хэлбэрээр ХХААХҮЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн [ICD@mofa.gov.mn](mailto:ICD@mofa.gov.mn) хаягаар ирүүлэхийг зөвлөж байна.

Сонирхсон этгээд бүрдүүлэх бичиг баримтыг ХХААХҮЯ-ны веб хуудасны “Сонгон шалгаруулалт” хэсгээс татан авч болно.

*ХАЯГ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,  
Засгийн газрын 9 дүгээр байр, 6 дугаар давхар, 605 тоот өрөө,  
Энхтайваны өргөн чөлөө 16а,  
Улаанбаатар-13381, МонголУлс.*

*Утас: 51261908*